



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын харилцааны салбарын шилдгийг шалгаруулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “Газрын харилцааны салбарын шилдгийг шалгаруулах журам”-ыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/262 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.


ДАРГА




Ц.ГАНХҮҮ



Газар зохион байгуулалт, геодези, зураг  
зүйн газрын даргын 2020 оны *А* дугаар  
тушаалын хавсралт



## ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ШИЛДГИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Газрын харилцааны салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлж, ажил үүргээ амжилттай хэрэгжүүлсэн хамт олон, менежер, албан хаагчдыг шалгаруулан, идэвхи, санаачлага, ажлын амжилтыг үнэлж, алдаршуулах, урамшуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /цаашид "агентлаг" гэх/, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, тэдгээрт ажиллаж буй албан хаагчид хамрагдана.

### Гурав. Шилдгийн төрөл

3.1. Газрын харилцааны салбарын шилдгүүдийг дараах төрлөөр шалгаруулна. Үүнд:

- 3.1.1. Шилдэг байгууллага
- 3.1.2. Шилдэг нэгж
- 3.1.3. Шилдэг менежер
- 3.1.4. Шилдэг ажилтан
- 3.1.5. Шилдэг газрын даамал

3.2. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба болон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаар нь "ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА" төрлөөр 3 байгууллагыг;

- 3.2.1. Тэргүүн;
- 3.2.2. Дэд;
- 3.2.3. Гутгаар байр.


3.3. Агентлагийн нэгжүүдээс тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаар "ШИЛДЭГ НЭГЖ" төрлөөр 1 нэгжийг;

3.4. Агентлагийн нэгж, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын тухайн жилд шинээр санаачлан, хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээгээр нь "ШИЛДЭГ АЖИЛ" төрлөөр 2 ажил, үйлчилгээг;

3.5. Байгууллага, хамт олноо оновчтой удирдан зохион байгуулж, мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллаж, салбарт хэмжээнд гаргасан амжилтаар "ШИЛДЭГ МЕНЕЖЕР" төрлөөр 3 менежерийг;

3.5.1. аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга - 1

3.5.2. агентлагийн нэгжийн дарга - 1;





3.5.3. аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нэгжийн дарга, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны нэгжийн дарга болон дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга - 1.

3.6. Байгууллагын зорилго, ажлын үр дүнг дээшлүүлэхэд идэвх санаачлага гаргаж, бусдыгаа хойшуучилсан амжилтаар нь “ШИЛДЭГ АЖИЛТАН” төрлөөр 4 ажилтанг;

3.6.1. агентлагийн ахлах мэргэжилтэн - 1;

3.6.2. агентлагийн мэргэжилтэн, ажилтан - 1;

3.6.3. аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтэн -1;

3.6.4. аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн, ажилтан -1.

3.7. Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэн, идэвх санаачлага гарган, бусдыгаа хойшуучсан амжилтаар “ШИЛДЭГ ГАЗРЫН ДААМАЛ” төрлөөр 5 даамлыг;

**Дөрөв. Нэр дэвшүүлэх**

4.1. Шилдгийн төрөл тус бүрт дор дурдсанаар нэр дэвшүүлэх бөгөөд энэхүү журмын 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу материалаа бэлтгэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор агентлагт ирүүлнэ. Үүнд:

4.1.1. “Шилдэг байгууллага” төрөлд агентлаг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албыг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.2. “Шилдэг нэгж” төрөлд агентлагийн нэгж өөрсдөө нэрээ дэвшүүлнэ.


4.1.3. “Шилдэг ажил”-ын төрөлд агентлагийн нэгж, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын алба өөрсдөө тухайн жилд шинээр санаачлан хийсэн ажил, үйлчилгээгээ нэр дэвшүүлнэ.

4.1.4. “Шилдэг менежер”-ийн “аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга” төрөлд агентлаг нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргыг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.5. “Шилдэг менежер”-ийн “Агентлагийн нэгжийн дарга” төрөлд агентлаг нь нэгжийн даргыг шууд нэр дэвшүүлнэ.

4.1.6. “Шилдэг менежер”-ийн “Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын нэгжийн дарга, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны нэгжийн дарга болон дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга” төрөлд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Газрын удирдлагын нэгжийн даргыг, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба нь нэгжийн дарга болон дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга нараас хоёр хүртэл тооны менежерийг нэр дэвшүүлнэ.

4.1.7. “Шилдэг ажилтан”-ы “Агентлагийн ахлах мэргэжилтэн”, “Агентлагийн мэргэжилтэн, ажилтан” төрөлд агентлагийн нэгж нь төрөл тус бүрт нэг хүртэл тооны албан хаагчийг нэр дэвшүүлнэ.





4.1.8. “Шилдэг ажилтан”-ны “аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтэн”, “Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн, ажилтан” төрөлд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар төрөл тус бүрт нэг хүртэл, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба нь төрөл тус бүрт хоёр хүртэл тооны албан хаагчийг нэр дэвшүүлнэ.

4.1.9. “Шилдэг газрын даамал”-ын төрөлд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь нэг хүртэл тооны даамлыг нэр дэвшүүлнэ.

**Тав. Шалгуур үзүүлэлт**

5.1. Шилдэг хамт олны “Шилдэг байгууллага”, “Шилдэг нэгж” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА /3.2/	Агентлагийн нэгж /3.3/
1.	Тухайн оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ (0-50 оноо)	+	+
2.	Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ (0-9 оноо)	+	+
3.	Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байдал (0-8 оноо)	+	+
4.	Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох чиглэлээр зохион байгуулсан ажил (0-8 оноо)	+	+
5.	Тухайн онд хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн (0-20 оноо) <i>Тайлбар: Агентлагийн даргын батадсаг нэгдсэн удирдамжаар тухайн жилд хийгдсэн хяналт, шинжилгээний үнэлгээг тооцно.</i>	+	+
6.	Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байдал (0-10 оноо) <i>Тайлбар: Тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаатай тайлангууд хамаарна.</i>	+	+
7.	Орлогын төлөвлөгөөний биелэлт (0-10 оноо)	+	
8.	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн ажил (0-5 оноо)	+	
9.	Нийт оноо	120 оноо	105 оноо

5.2. “Шилдэг ажил” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Шилдэг ажил /3.4/
1.	Тухайн онд шинээр хийж хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний зорилт, хүрэх түвшин, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг албажуулан, хариуцах эзэн, хугацааг тодорхойлсон байдал (0-20 оноо)	+

ЭХ ХУВЬ  
Түвшин 8/120




2.	Тухайн ажил хэрэгжиж эхэлсэн, төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн, үр дүн гарсан байдал (0-40 оноо)	+
3.	Тухайн ажил хэрэгжиж дууссан, хүрэх түвшинд хүрсэн, үр дүн гарсан байдал (0-40 оноо)	+
4.	Нийт оноо	100 оноо

5.3. “Шилдэг менежер” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Аймгийн ГХБХБГ-ын дарга, нийслэлийн ГЗБА-ны дарга /3.5.1/	Агентлагийн нэгжийн дарга /3.5.2/	Аймгийн ГХБХБГ-ын нэгжийн дарга, Нийслэл, дүүргийн ГЗБА-ны дарга /3.5.3/
1.	Байгууллагын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ (0-30 оноо)	+	+	+
2.	Тухайн жилд газрын харилцааны чиглэлээр шинээр санаачилсан ажил, үйлчилгээ, түүнийг хэрэгжүүлсэн байдал (0-20 оноо) <i>Тайлбар: эрх бүхий байгууллагаар батлуулж, санхүүжилтийг шийдвэрлэсэн, хэрэгжилтийг зохион байгуулсан байдал</i>	+	+	+
3.	Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байх (0-10 оноо)	+	+	+
4.	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулсан байдал (0-5 оноо)	+		
5.	Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал (0-10 оноо)	+		
6.	Ажилтнуудын ажиллах орчин нөхцлийг сайжруулсан байдал (0-10 оноо)	+		
7.	Ажилтнуудыг сургалтад хамруулсан байдал (0-5 оноо)	+	+	+
8.	Санхүүгийн болон сахилга хариуцлагын зөрчилгүй байх (0-10 оноо)	+	+	+
9.	Нийт оноо	100 оноо	75 оноо	75 оноо

5.4. “Шилдэг ажилтан” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Шилдэг ажилтан /3.6/
1.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн үнэлгээ (0-50 оноо)	+

  
**ЭХ ХУВЬ**  
 Тусгаар... 8/10



2.	Нэгжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ, санал санаачлага гаргаж хэрэгжүүлсэн байдал (0-10 оноо)	+
3.	Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байдал (0-10 оноо)	+
4.	Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байдал (0-10 оноо)	+
5.	Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт (0-5 оноо)	+
6.	Албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан байдал (0-5 оноо)	+
7.	Үүрэг даалгаврын биелэлт (0-5 оноо)	+
8.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байдал (0-5 оноо)	+
9.	Нийт оноо	100 оноо

5.5. “Шилдэг газрын даамал” төрлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Шилдэг газрын даамал /3.7/
1.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, жилийн эцсийн үнэлгээ (0-50 оноо)	+
2.	Хариуцсан үйл ажиллагаатай холбоотой шинээр санаачилсан ажил, түүнийг хэрэгжүүлсэн байдал (0-20 оноо) <i>Тайлбар: эрх бүхий байгууллагаар батлуулсан байдал, санхүүжилтийг шийдвэрлэсэн байдал, хэрэгжилтийг зохион байгуулсан байдал</i>	+
3.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (0-10 оноо)	+
4.	Төрийн үйлчилгээг сайжруулах, шуурхай болгох талаар хэрэгжүүлсэн ажил (0-10 оноо)	+
5.	Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хэл найруулга болон зөв бичих дүрмийн алдаагүй тайлагнасан байх (0-5 оноо)	+
6.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байдал (0-5 оноо)	+
7.	Нийт оноо	100 оноо

**Зургаа. Шалгаруулалт**

6.1. Агентлагийн даргын тушаалаар томилогдсон шилдгийг шалгаруулах комисс нь шилдэг төрөл тус бүрт нэр дэвшсэн материалд үндэслэн шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч, хамгийн өндөр оноо авсан байгууллага, албан хаагч болон ажлыг журамд заасан тооны хязгаарт багтаан шалгаруулна.

6.2. Комисс нь материал хүлээн авах хугацаа дууссан өдөр нэр дэвшигчдийн жагсаалтыг гаргаж, ажлын 3 хоногт багтаан шалгаруулна.

6.3. Комисс нь шалгаруулалтын дүнг газрын Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн агентлагийн даргын шийдвэрээр баталгаажуулна.

  
**ЭХ ХУВЬ**  
 Тушаал А/НЭ



6.4. Шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн материал шалгуур үзүүлэлтийн шаардлага хангаагүй, хугацаа хоцроосон, шилдэгийн төрөлд нэр дэвшүүлэх материал ирээгүй бол тухайн төрөлд шалгаруулалт хийхгүй байж болно.

**Долоо. Бүрдүүлэх материал**

7.1. Агентлаг, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба шилдгийн төрөлд нэр дэвшүүлэхдээ дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

7.1.1. Энэхүү журмын 5.1, 5.3-д заасан төрөлд нэр дэвшүүлсэн бол байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, энэхүү журмын 5.4, 5.5-д заасан төрөлд тухайн албан хаагчийн улирал бүрийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг тус тус ирүүлнэ.

7.1.2. Энэхүү журмын 7.1.1-д заасан биелэлтээс бусад шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын товч тайланг 3000 тэмдэгтэд багтаан бичиж ирүүлнэ.

7.1.3. Шалгуур үзүүлэлтийн хүрээнд товч тайлангийн хамт фото зураг, бичлэг ирүүлж болох бөгөөд энэ талаар албан бичигт тодорхой CD болон Flash дээр хуулбарлан ирүүлнэ.

**Найм. Шагнал, урамшуулал**

8.1. Идэвхи санаачлага гаргаж тухайн жилийн зорилт, гүйцэтгэл, ажлын амжилтаараа шалгарсан шилдэг хамт олон, албан хаагчдад батламж, мөнгөн урамшуулал олгоно.

- 8.2. Шилдэг хамт олны төрлийг дараах байдлаар шагнаж, урамшуулна.
  - 8.2.1. “Шилдэг байгууллага” Тэргүүн байр “Батламж”, 3.000.000 төгрөг;
  - 8.2.2. “Шилдэг байгууллага” Дэд байр “Батламж”, 2.000.000 төгрөг;
  - 8.2.3. “Шилдэг байгууллага” Гутгаар байр “Батламж”, 1.000.000 төгрөг;
  - 8.2.4. Агентлагийн “Шилдэг нэгж” “Батламж” 500.000 төгрөг.
- 8.3. “Шилдэг ажил”-тус бүр “Батламж”, 500.000 төгрөг.
- 8.4. “Шилдэг менежер” тус бүр “Өргөмжлөл”, 500.000 төгрөг.
- 8.5. “Шилдэг ажилтан” тус бүр “Өргөмжлөл”, 500.000 төгрөг.
- 8.6. “Шилдэг газрын даамал” тус бүр “Өргөмжлөл”, 500.000 төгрөг.

**Ес. Шилдгийн шагнал гардуулах**

9.1. “Агентлагийн шилдэг нэгж”, “Шилдэг менежер”, “Шилдэг ажилтан”-ы шагналыг агентлагийн Шинэ жилийн баярын арга хэмжээн дээр гардуулна.

9.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны “Шилдэг байгууллага”, “Шилдэг менежер”, “Шилдэг ажил”, “Шилдэг ажилтан”, “Шилдэг газрын даамал”-ын шагналыг жил бүрийн газрын харилцааны салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн дээр гардуулна.

----oOo---

